



Үндэсний статистикийн  
хороо

# 2019.11

## Сарын танилцуулга



### ИНФЛЯЦ, ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ



## **АГУУЛГА**

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	3
ОРШИЛ.....	4
ИНФЛЯЦ.....	5

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 11 дүгээр сард .....	5
Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 11 дүгээр сард.....	6
Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 11 дүгээр сард.....	7
Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, бараа, үйлчилгээний бүлгээр, улс, бүсээр, хувиар, 11 дүгээр сард.....	8
Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар, жил бүрийн 11 дүгээр сард.....	9

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, 2016-2019 он, жил бүрийн 11 дүгээр сард.....	6
Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь.....	8
Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 11 дүгээр сард (өмнөх сар=100%).....	10
Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувь, (өмнөх оны 12 дугаар сар = 100%).....	11
Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 11 дүгээр сард.....	11
Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 сар=100%).....	13
Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	13

## ОРШИЛ

Инфляцыг хэмжих хэд хэдэн арга байдгийн нэг нь хэрэглээний үнийн индекс юм. Инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс болдог. Түүнчлэн хэрэглээний үнийн индексийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргын тооцоонд болон эцсийн ашиглалтын тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашиглана.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үндэсний Статистикийн Хороо 1991 оноос Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар хэрэглээний үнийн индексийг тооцож эхэлсэн ба түүнээс хойш суурь, сагс, жинг 1995, 2000, 2005, 2010, 2015 онуудад шинэчилсэн. 1991-2006 он хүртэл Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр хэрэглээний үнийн улсын индексийг төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан хэрэглээний үнийн улсын индексийн тооцоонд аймгийн хэрэглээний үнийн индексийг оруулах шаардлагатай болсон. 2006 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

2017 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг 2015 суурьт шилжүүлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу 373 (Улаанбаатар хотод 344, аймгуудад 238 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр хэрэглээний үнийн индексийг тооцож байна.

## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

### Инфляц


Инфляцын түвшин 2016 оны 11 дүгээр сард 0.5 хувь, 2017 оны 11 дүгээр сард 6.5 хувь, 2018 оны 11 дүгээр сард 8.1 хувьтай гарч байсан бол 2019 оны 11 дүгээр сард 5.2 хувь болж өмнөх оноос 2.9 пунктээр буурсан байна.

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 11 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 XI	2017 XI	2018 XI	2019 XI
<b>Ерөнхий индекс</b>	<b>100</b>	<b>0.5</b>	<b>6.5</b>	<b>8.1</b>	<b>5.2</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	-0.2	2.1	1.9	2.4
Согтууруулах ундаа, тамхи	4.4	0.0	0.2	0.4	0.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	0.4	0.7	0.8	1.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	0.0	0.6	1.5	0.4
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	0.1	0.2	0.3	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	0.1	0.3	0.5	0.1
Тээвэр	14.4	-0.3	1.4	1.6	-0.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	0.0	0.1	0.3	0.3
Боловсролын үйлчилгээ	4.8	0.2	0.3	0.3	0.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0				
		0.0	0.0	0.2	0.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	0.1	0.5	0.2	0.2

Инфляц 2019 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 5.2 хувьтай гарлаа. Үүнийг бүлгүүдийн оролцооны түвшингээр авч үзвэл 2.4 нэгж буюу (45.0 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгээс, 1.1 нэгж буюу (20.3 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгээс, 0.5 нэгж буюу (10.0 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. 2018 оны 11 дүгээр сард хүнсний бараа, ундаа, усны бүлэг инфляцид 23.4 хувиар нөлөөлж байсан бол 2019 оны 11 дүгээр сард 45.0 хувь болж 21.6 пунктээр өссөн байна.

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 11 дүгээр сард



Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 11 дүгээр сард

Үзүүлэлт	2017 XI		2018 XI		2019 XI	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
<b>Ерөнхий индекс</b>	<b>6.5</b>	<b>100.0</b>	<b>8.1</b>	<b>100.0</b>	<b>5.2</b>	<b>100.0</b>
Импортын барааны нөлөө	3.3	51.0	3.2	39.4	1.6	30.0

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг.

2019 оны 11 дүгээр сард инфляц 5.2 хувь гарсны 1.6 нэгж буюу 30.0 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Энэ нь 2018 оны 11 дүгээр сартай харьцуулахад нөлөөлөл нь 9.4 пунктээр буурсан байна.

Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 11 дүгээр сард


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2019 XI</u> 2018 XI	<u>2019 XI</u> 2018 XII	<u>2019 XI</u> 2019 X
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>105.2</b>	<b>104.6</b>	<b>99.6</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	109.5	107.6	97.8
Согтууруулах ундаа, тамхи	4.4	103.1	102.8	100.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	106.5	106.0	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	104.0	102.9	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	103.4	103.2	100.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	103.6	103.1	100.1
Тээвэр	14.4	97.4	98.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	109.6	109.3	100.1
Боловсролын үйлчилгээ	4.8	109.6	109.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	109.7	109.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.4	104.5	104.4	100.1

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.5 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 21.9 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.2 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 2.9 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 4.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.6 хувь (мах, махан бүтээгдэхүүн 18.9 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх сараас 0.4 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувиар (мах, махан бүтээгдэхүүн 9.2 хувь) буурсан нь голлон нөлөөлсөн байна

Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь



Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, жил бүрийн 11 дүгээр сард, хувь

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>100.5</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>101.0</b>	<b>101.8</b>	<b>101.4</b>
2016 XI	Бараа	100.1	99.3	99.3	101.0	101.9	100.6
	Үйлчилгээ	101.8	101.7	102.5	101.2	101.3	104.2
	<b>Ерөнхий индекс</b>	<b>106.5</b>	<b>107.6</b>	<b>106.1</b>	<b>104.6</b>	<b>105.2</b>	<b>104.9</b>
2017 XI	Бараа	107.4	108.9	106.6	105.1	105.9	106.1
	Үйлчилгээ	103.8	104.5	104.3	103.0	102.5	100.7
	<b>Ерөнхий индекс</b>	<b>108.1</b>	<b>109.3</b>	<b>106.8</b>	<b>106.2</b>	<b>106.7</b>	<b>107.3</b>
2018 XI	Бараа	108.9	110.4	107.3	106.7	107.8	108.4
	Үйлчилгээ	105.5	106.6	105.2	104.4	102.4	103.2
	<b>Ерөнхий индекс</b>	<b>105.2</b>	<b>105.0</b>	<b>105.6</b>	<b>105.7</b>	<b>104.8</b>	<b>106.5</b>
2019 XI	Бараа	104.8	104.5	104.2	105.9	104.5	106.4
	Үйлчилгээ	106.4	106.3	110.4	105.0	105.4	106.9

Хэрэглээний үнийн индексийг бараа болон үйлчилгээний бүлгээр задалж 2018 оноос бүсийн хэмжээнд тооцож эхэлсэн. 2016 оны 11 дүгээр сард үйлчилгээний үнийн өсөлт түлхүү явагдаж байсан нь 2019 оны 11 дүгээр сард хадгалагдаж байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Зүүн бүсэд барааны үнийн өсөлт 6.4 хувь, Баруун бүсэд үйлчилгээний үнийн өсөлт 10.4 хувь гарсан нь бусад бүсүүдээс хамгийн өндөр үзүүлэлт болж байна (Хүснэгт 4).



Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, улс, бүсээр, хувиар, 11 дүгээр сард

<b>Бүс, аймаг</b>	<b>2018 XI</b>	<b>2019 XI</b>
<b>Ерөнхий индекс</b>	<b>108.1</b>	<b>105.2</b>
<b>Баруун бүс</b>	<b>106.8</b>	<b>105.6</b>
Баян-Өлгий	107.6	105.5
Говь-Алтай	107.4	105.4
Завхан	105.9	105.2
Увс	106.8	107.2
Ховд	105.7	104.4
<b>Хангайн бүс</b>	<b>106.2</b>	<b>105.7</b>
Архангай	107.3	106.1
Баянхонгор	106.9	104.7
Булган	105.9	105.2
Орхон	105.4	105.6
Өвөрхангай	109.8	105.7
Хөвсгөл	102.9	106.4
<b>Төвийн бүс</b>	<b>106.7</b>	<b>104.8</b>
Говьсүмбэр	105.8	105.1
Дархан-Уул	106.4	105.9
Дорноговь	106.4	104.9
Дундговь	106.5	106.5
Өмнөговь	109.2	103.6
Сэлэнгэ	106.4	103.5
Төв	106.1	104.9
<b>Зүүн бүс</b>	<b>107.3</b>	<b>106.5</b>
Дорнод	106.6	107.8
Сүхбаатар	107.2	104.8
Хэнтий	108.1	106.5
<b>Улаанбаатар</b>	<b>109.3</b>	<b>105.0</b>

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх сараас Сэлэнгэ, Говьсүмбэр, Дорноговь, Увс, Баянхонгор, Хөвсгөл, Булган аймгуудад 0.1-0.6 хувиар буурч, бусад аймагт 0.2-0.8 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард Сэлэнгэ аймагт 0.6 хувиар буурч, Ховд аймагт 0.8 хувиар өссөн нь хамгийн их байна (Зураг 3).

Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 11 дүгээр сард (өмнөх сар= 100%)



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2019 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.0 хувиар буурч, өмнөх оны эцсээс 4.3 хувь, өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 9.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 8.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 2.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.7 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 3.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 4.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 7.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.0 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2019 оны 11 дүгээр сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 11.0 хувь буюу 38 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 4.1 хувь буюу 14 бараа, үйлчилгээний үнэ буурч, 84.9 хувь буюу 292 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 24 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувиар, (өмнөх оны 12 дугаар сар = 100%)




2019 оны 11 дүгээр сард мах махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны эцсээс 18.9 хувиар өссөн байна. Үүнд үхрийн махны үнэ 24.0 хувь, хонины ястай махны үнэ 16.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.



Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 11 дүгээр сард


2019 оны 11 дүгээр сард оны эхнээс инфляц 4.6 хувиар өссөн бөгөөд 1.4 нэгж буюу 30.5 хувь нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн цул махны дундаж үнэ 2019 оны 11 дүгээр сард 13257 төгрөгийн үнэтэй байгаа нь 2016 оны 11 сараас 83.3 хувь, 2017 оны 11 сараас 62.4 хувь, 2018 оны 11 сараас 41.8 хувиар өссөн байна.

Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн ястай махны дундаж үнэ 2019 оны 11 дүгээр сард 10103 төгрөгийн үнэтэй байгаа нь 2016 оны 11 сараас 72.3 хувь, 2017 оны 11 сараас 50.6 хувь, 2018 оны 11 сараас 26.3 хувиар өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа хонины ястай махны дундаж үнэ 2019 оны 11 дүгээр сард 7708 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд 2016 оны 11 сараас 73.5 хувь, 2017 оны 11 сараас 43.3 хувь, 2018 оны 11 сараас 15.2 хувиар өссөн байна.

Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 сар=100%)



2019 оны 11 дүгээр сарын байдлаар бензин, түлшний үнэ өмнөх оны эцсээс 2.2 хувиар буурсан бол, өмнөх сараас 0.1 хувиар өсжээ.

Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр



2019 оны 11 дүгээр сард АИ-92 бензиний дундаж үнэ 1837 байгаа нь 2016 оны 11 сараас 20.0 хувь, 2017 оны 11 сараас 12.7 хувиар өндөр байсан бол 2018 оны 11 сараас 7.2 хувиар буурсан байна.